

**ШАРЫН ГОЛ СУМ, "ИӨОТ" ХХК-ТАЙ
НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЛААР
ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

2021.07.25

№5

Шарын гол сум

НЭГ: ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Захиргааны ерөнхий хууль, Ашигт малтмалын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Усны тухай, Газрын тухай, Хөрс хамгаалах, Цөлжилтөөс сэргийлэх тухай, Эрүүл ахуйн тухай хууль, Хог хаягдлын тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Хөдөлмөрийн тухай, Олон улсын гэрээний тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Авлигатай тэмцэх тухай, Шилэн дансны тухай хуулиуд болон холбогдох бусад хууль тогтоомжуудыг удирдлага болгон харилцан тохиролцсоны үндсэн дээр хамтран ажиллахаар энэхүү гэрээг байгууллаа.

ХОЁР: ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

Шарын гол сумын нутаг дэвсгэрт хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, байгалийн баялгийг ашиглах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ажиллагсад болон оршин суугч иргэдийн эрүүл, аюулгүй байдал, орчны эрүүл ахуйг хамгаалах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж, орон нутгийн иргэдийн өмнө хүлээсэн үүргийг тодорхой болгож, нийгмийн хариуцлагын талаар харилцан ашигтай, хамтран ажиллахад гэрээний зорилго оршино.

ГУРАВ: ТАЛУУДЫН ЭРХ ҮҮРЭГ

3.1. Шарын гол сумын Засаг даргын Тамгын газар нь дараах эрх эдэлж үүрэг хүлээнэ.

- 3.1.1. Уурхайн үйл ажиллагаа явуулахад шаардагдах нөхцөлөөр хангах
- 3.1.2. Уурхайн үйл ажиллагааг сайжруулах талаар гаргасан санал, хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих
- 3.1.3. Гэрээнд заасан үүргээ зохих ёсоор хугацаандаа биелүүлэхийг

шаардах, гэрээг хэрэгжүүлэхэд шударгаар хамтран ажиллах

3.1.4. Гэрээний хэрэгжилт гэрээтэй холбоотой үйл ажиллагаанд хяналт тавих эрхтэй хамтын ажиллагааны хороо байгуулан зохих журмын дагуу ажиллуулах

3.1.5. ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнүүд хууль эрх зүйн зөвөлгөө, туслалцаа үзүүлэх

3.1.6. Уурхайд гарсан аливаа гэмт хэрэг, гамшиг, осол аваарийн үед хуулийн хүрээнд төрийн үйлчилгээг цаг алдалгүй хүргэх

3.1.7. Хуульд заасан бусад асуудлаар хариуцлага хүлээнэ.

3.1.8. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, сумын ерөнхий хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын зарим төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг хүсэх

3.2. ИӨОТ ХХК нь дараах эрх эдэлж үүрэг хүлээнэ.

3.2.1. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд нэмэлт тодотгол хийлгэх, байгаль орчны менежментийн төлөвлөгөөндөө уул уурхайн үйл ажиллагааг байгаль орчинд хохирол багатай явуулах, нөхөн сэргээлт хийх, агаар мандал, ус, хөрсний бохирдолт, хүн амьтан, ургамалд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх цогц арга хэмжээг тусгаж сумын Засаг даргаар батлуулан мөрдөж ажиллана.

3.2.2. Хүрээлэн байгаа орчны бохирдолтыг зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, уурхайн шаталтаас үүссэн угаарын хий, тоосыг багасгах арга хэмжээг бодитоор хэрэгжүүлэх, мэдээллэх, эвдэгдсэн газарт жил бүр техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг чанартай хийж орон нутагт хүлээлгэн өгч, нийтийн хэрэгцээний зориулалтаар ашиглах боломж бүрдүүлэх

3.2.3. Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсад болон гадаадын иргэдийн ажиллах бололцоо нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй байдлын асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэхээс гадна сум орон нутгийн ажилгүй иргэдийг дэмжсэн мэргэжлийн үнэмлэх олгох сургалт явуулах ажилд санаачлагатай ажиллаж жилд тодорхой тооны иргэнийг байнгын болон түр ажлын байраар ханган ажиллах ба хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй байгаа ажилгүй иргэдийн мэдээллийг ЗДТГ-аас авах.

3.2.4. Орон нутгийнхаа жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжиж тэдний үйлдвэрлэсэн стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүн (ажлын хувцас, гутал, хүнсний бүтээгдэхүүн, модон материал) нийлүүлэх ажлыг зохион байгуулах

3.2.5. Спортын ордны гадна фасад засварын ажилд дэмжлэг үзүүлэх

3.2.6. Цаг үеийн шинжтэй бусад ажлыг санхүүжүүлэх

3.2.7. Сумын хэмжээнд байгалийн ган, зуд, ойн түймэр, үер ус, цаг уурын хүндрэл тохиолдсон үед хүн, хүч машин техникээр туслах талаар 2 тал хамтран ажиллах

3.2.8. Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн хугацаатай мэдээ тайлан, албан даалгавар, түүний хэрэгжилтийг хангаж заасан хугацаанд тогтмол ирүүлэх

ДӨРӨВ: ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА, ГЭРЭЭ ДҮГНЭХ

4.1. Хамтран ажиллах гэрээний хугацаа нь НЭГ жил байна.

4.2. Гэрээг хуульд зааснаас бусад тохиолдолд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр хугацаанаас өмнө гэрээг дуусгавар болгож болно.

4.3. Энэхүү гэрээний 6.2-д зааснаар гэрээг цуцлах тохиолдолд 1 сарын өмнө урьдчилан мэдэгдэх замаар гэрээнээс татгалзаж болно.

4.4. Шаардлагатай үед талуудын аль нэг нь санаачилсан тохиолдолд гэрээний заалтад өөрчлөлт оруулах асуудлаар санал оруулж болно.

4.5. Гэрээний хэрэгжилтийг хянах, үнэлгээ хийх болон төслийн талаар компани болон орон нутгийн иргэдийн өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэх зорилгоор улирал тутам хуралдаж, гэрээний хавсралтанд заасан журмыг баримталж ажиллана.

4.6. Жил бүр хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлыг гэрээний 3.2-т болон нэмэлт хавсралтаар баталгаажуулах бөгөөд уг хавсралт нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.7. Шаардлагатай чиглэлээр хоёр тал энэхүү гэрээний дагуу тусгайлан төлөвлөгөө гарган ажиллаж болно.

4.8. Хамтран ажиллах хугацааг хоёр тал харилцан тохиролцож 2 хувь үйлдэж гарын үсэг зурж баталгаажуулсанаар хүчин төгөлдөр болно.

ТАВ: ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА


5.1. Талууд гэрээний үүргийн биелэлтийн хүрээнд харилцан хариуцлага хүлээх бөгөөд нэг тал нь үүргээ биелүүлээгүй бол биелүүлээгүй үүргийн хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

5.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь төлөх үүрэгтэй

ЗУРГАА: МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

6.1. Талууд энэхүү гэрээний үүргийн биелэлттэй холбогдон гарсан бүх маргааныг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

6.2. Талууд энэхүү гэрээний 4.3-д зааснаар гуч хоногийн дотор зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд аль нэг тал нөгөөдөө бичгээр мэдэгдэл өгч, уг маргаан, зөрчил, шаардлагыг Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

ШАРЫН ГОЛ СУМЫГ ТӨЛӨӨЛЖ:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА  Г.ШИНЭХҮҮ
УТАС: 99705470
11000000000000000000

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

УЛААНБААТАР ХОТ
ИЭӨТ "ХХК-ИЙГ
ТӨЛӨӨЛЖИЙРХАЙН ДАРГА
 ХХЦ ДОРЖДАГВА
/ГЭРЭЭНИЙ/
УТАС: 88951966
6296424 АМ104099